

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2025.04.21

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ОРА-2025/01/НА-СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Орон нутгийн төсөвт байгууллагууд болон ОНӨҮГ-ууд
Аудитын нэр:	"Орхон аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Гүйцэтгэлийн аудитын алба	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитор О.Гантуяа, Ж.Наранчимэг

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн Нргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдсан эсэх.
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэл хангагдсан эсэх.
- Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт хангагдсан эсэх.

2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдсан эсэх.

Хариулт 1:

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2024 оны татварын орлогыг 241,748.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 245,965.0 сая төгрөг төвлөрч 4,216.0 сая төгрөг буюу 1.7 хувиар давж биелсэн байна.

Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 171.9 сая төгрөг, хөрөнгийн орлого 419.2 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 1,085.6 сая төгрөг, шууд бус орлого 1,484.0 сая төгрөг, АТБӨЯХАТатвар 88.9 сая төгрөг, хог хаягдлын хураамж 433.6 сая төгрөг, ус рашааны нөөц ашигласны төлбөр 358.2 сая төгрөгөөр давж, цалин хөлс түүнтэй адилтгах орлого 1,974.1 сая, улсын тэмдэгтийн хураамж 222.9 сая, газрын төлбөр 226.4 сая, ойн нөөц ашигласны төлбөр 18.4 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Өмнөх онтой харьцуулахад 2024 оны татварын орлого 11,490.6 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.6-д “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ. 23.6.1-д “аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасан байтал Сангийн яам Орхон аймгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 153,000.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байсныг 53,000.0 сая төгрөгийг хасаж 100,000.0 сая төгрөгөөр бууруулан тодотгосон, гүйцэтгэлээр төлөвлөсөн 100,000.0 сая төгрөгийг хуваарилсантай холбоотой байна.

Татварын бус орлогыг 108,810.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 65,487.8 сая төгрөг төвлөрч 43,323.1 сая төгрөгөөр орлого тасарсан байна. Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих орлого 44.5 хувийн, хөрөнгийн орлого 17.5 хувийн, ОНХС-аас шилжүүлсэн орлого 96.5 хувийн нийт 60.2 хувийн гүйцэтгэлтэй биелж 39.8 хувиар татварын бус орлого тасарсан байна.

2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:

Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.

Хариулт 2:

Орхон аймгийн нэгдсэн төсвийн 2024 оны нийт зардлыг 392,657.2 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 316,663.2 сая төгрөг зарцуулж, 75,994.0 сая төгрөгийг хэмнэж, 80.6 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оны гүйцэтгэлээс 43,290.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэл 76.1 хувьтай байгаа нь 2024 оны сүүлээр дулааны үнэ тариф 25% өсөхөөр тооцож төсөвт тусгах чиглэлийг Сангийн яамнаас өгсний дагуу тодотголоор нэмэгдүүлж, төсөвт тусгасан боловч үнэ нэмэх хугацаа хойшлогдсонтой холбоотой хэмнэлт үүссэн байна.

Томилолт, зочны зардал 2023 оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 33.5 хувиар өссөн нь дотоод болон гадаад томилолт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засаг даргын нөөц сангийн үлдэгдлийг 30 хувийн нөөцтэй байх чиглэл барьж ажилласнаар оны эцэст бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 76.2 хувьтай байна.

2024 онд ОНХО, ОНХСан, АЗС-ийн нийт хөрөнгө оруулалтын зардал 164,743.2 сая төгрөг батлагдсанаас 101,704.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 61.7%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь 2024 оны ХО-ын ажлаас 3,000.0 сая төгрөгийн бодит хэмнэлт гарч, бусад ажлууд нь он дамжин хийгдэхээр шилжих үлдэгдлээр батлагдсантай холбоотой 75,994.0 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Хөрөнгийн зардал 101,704.6 сая төгрөг болж өмнөх оноос 42,058.4 сая төгрөгөөр өссөн нь 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санхүүжилт нэмэгдсэн, мөн Засгийн газрын шийдвэрээр Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр аймгийн автозамыг шинэчлэх ажил эхэлсэн зэрэгтэй холбоотой хөрөнгийн зардал өмнөх оноос өссөн байна.

Улсын төсвийн төрийн захиргааны 85 байгууллагын төрийн захиргааны албан хаагч болон төрийн үйлчилгээний албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 8,268.7 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 6,470.8 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалинд олгож, 31 байгууллагын нийт 105.0 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

2.2.3 Гол асуулт / аудитын дэд зорилт 3:

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэл хангагдсан эсэх.

Хариулт 3:

Тайлант онд 177,477.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 712 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулж, 166,681.4 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулж, 10,796.1 сая төгрөгийг хэмнэж, хөтөлбөр арга хэмжээний биелэлт 93.9 хувьтай хэрэгжсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 26 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. Төсвийн нийт зардлыг 525,887.0 сая төгрөгөөр төлөвлөж, 449,893.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 84.3 хувьтай хэрэгжсэн байна.

2.2.4 Гол асуулт / аудитын дэд зорилт 4:

Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт хангагдсан эсэх.

Хариулт 4:

Гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төслийн зээлийн төлбөрт 2022 онд 13,621.4 сая төгрөг, 2023 онд 1,225.9 сая төгрөг, тайлант онд 2,956.8 сая төгрөг нийт 17,798.9 сая төгрөгийг Сангийн яам суутган тооцсон боловч төслийн гүйцэтгэл 99 хувьтай байна. Төслийн зээлийн төлбөрийг орон нутгийн төсвөөс жил бүр төлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

Өмнөх аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Газрын эрхийн шимтгэлийн орлогыг эрдэнэт санд төвлөрүүлэхгүй, орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэхээр төсөвт өөрчлөлт оруулан баталсан байна. Ерөнхий орлогын дансанд 133.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төрийн байгууллагуудад олгож байгаа нэмэгдэл цалинг төсөвт байгууллагуудаас сар бүр цалингийн тооцооллыг авч, тооцоололд үндэслэн олгож, 31 байгууллагын нийт 105.0 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлжээ.

2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө салбар бүрээр хэлэлцүүлэг явуулж, ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалаар боловсруулсан бөгөөд зураг төсөв судалгааг үндэслэн төлөвлөсөн байна.

2.3 Аудитын гол дүгнэлт

ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙГ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ УЯЛДУУЛАН, АЙМАГ, СУМЫН ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨЖ БАЙХ

2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн Засаг дарга	3	0	3			
2	Баян-өндөр сумын Засаг дарга	1	0	1			
3	Жаргалант сумын Засаг дарга	1	0	1			
4							
	ДҮН	5		5	-		-